



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 0/241

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн “Био-Асралт” өрхийн
эрүүл мэндийн төвийн эргэлтийн
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 249,900 /хоёр зуун дөчин есөн мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн “Био-Асралт” өрхийн эрүүл мэндийн төв /А.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 90,000.00 /ерэн мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 2 нэр төрлийн нийт 159,900.0 /нэг зуун тавин есөн мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн “Био-Асралт” өрхийн эрүүл мэндийн төв /А.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115070000653

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 07 ны өдрийн
07/07 тоот тушаалын хавсралт



Хөрөнгө данснаас хасах тухай

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо "Био-Асралт" ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-н шийдвэр
Тавилга эд хогшил											
1	Шүүгээ /тумбучка/	11	ш	1	79,900.00	79,900.00	79,900.00	-	урагдаж цоорсон	актлах	татах
2	Шилэн шкаф	11	ш	1	80,000.00	80,000.00	80,000.00	-	урагдаж цоорсон	актлах	татах
Тавилга эд хогшлын дүн				2		159,900.00	159,900.00				
Программ хангамж											
1	Өмчийн программ	8	ш	1	90,000.00	90,000.00	90,000.00	-	ашиглах боломжгүй	актлах	устгах
Программ хангамжийн дүн						90,000.00	90,000.00				
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						249,900.00	249,900.00				
Үүнээс татан төвлөрүүлэх хөрөнгө						159,900.00	159,900.00				
Актлах хөрөнгө						90,000.00	90,000.00				